



**НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Багануур дүүргийн Засаг даргын
2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн "д", 25 дугаар зүйлийн 25.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.1, 17.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит III хуралдаанаас хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг дарга С.Даваасүрэнд даалгасугай.

2.1. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт батлах

2.2. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн дүүргийн төсөвт тусган хэрэгжүүлэх

2.3. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудын биелэлтийг гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр танилцуулах

3. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА



Т.ОТГОНБОЛД